



I-VI/2021


Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 18



Экспорт өмнөх сараас 38.0 сая америк доллароор буурлаа

Монгол Улс 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 138 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 7.4 тэрбум америк доллар, үүнээс экспорт 4.1 тэрбум америк доллар, импорт 3.3 тэрбум америк доллар боллоо. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 (39.4%) тэрбум америк доллароор, экспорт 1.3 (45.4%) тэрбум америк доллароор, импорт 801.0 (32.6%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин 2021 оны 6 дугаар сард экспорт 788.3 сая америк доллар, импорт 659.5 сая америк доллар болж, өмнөх сараас экспорт 38.0 (4.6%) сая америк доллароор буурч, импорт 19.2 (3.0%) сая америк доллароор өссөн байна.

Зураг 1. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллароор



Гадаад худалдааны тэнцэл 2020 оны эхний хагас жилд 368.0 сая америк долларын ашигтай байсан бол 2021 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 482.2 сая америк доллароор өсөж, 850.2 сая америк долларын ашигтай гарлаа.


БНХАУ-тай 2021 оны эхний хагас жилд 5.0 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 68.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Экспортын хэмжээ, гол түнш улсаар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Улс орон	2019 I-VI		2020 I-VI		2021* I-VI	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	3 939.0	100.0	2 828.2	100.0	4 111.3	100.0
БНХАУ	3 566.5	90.5	2 113.5	74.7	3 706.3	90.2
Швейцар	0.2	0.0	499.0	17.6	142.3	3.5
БНСУ	9.0	0.2	9.1	0.3	93.4	2.3
Сингапур	17.2	0.4	74.8	2.6	57.5	1.4
ОХУ	36.6	0.9	24.4	0.9	50.0	1.2
Бусад	309.4	7.9	107.4	3.8	61.7	1.5

БНХАУ-д экспортлосон бараа бүтээгдэхүүний 25.7 хувийг чулуун нүүрс, 35.4 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортлосон барааны 99.1 хувийг, БНСУ-д экспортлосон барааны 82.3 хувийг алт эзэлж байна.

Зураг 2. Уул уурхайн гаралтай экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүн, сая америк доллароор, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Экспорт 2021 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум америк доллароор өсөхөд төмрийн хүдэр, баяжмалын экспорт 267.6 сая америк доллар, зэсийн баяжмалын экспорт 571.8 сая америк доллар, нүүрсний экспорт 337.5 сая америк доллароор нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Харин 2021 оны 5 дугаар сард 1.4 сая тонн нүүрс экспортлосон бол 2021 оны 6 дугаар сард өмнөх сараас 672.4 мянган тонноор буурч, 723.5 мянган тонн болсон нь экспорт өмнөх сараас 38.0 сая америк доллароор буурахад голлон нөлөөлжээ.

Хүснэгт 2. Импортын хэмжээ, гол түнш улсаар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар


Улс орон	2019 I-VI		2020 I-VI		2021* I-VI	
	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь	Дүн, сая америк доллар	Дүнд эзлэх хувь
Дүн	2 893.8	100.0	2 460.1	100.0	3 261.1	100.0
БНХАУ	931.8	32.2	859.7	34.9	1 310.0	40.2
ОХУ	768.6	26.6	675.0	27.4	847.5	26.0
Япон	311.4	10.8	195.4	7.9	205.3	6.3
БНСУ	131.8	4.6	106.6	4.3	138.9	4.3
ХБНГУ	87.6	3.0	88.7	3.6	118.8	3.6
АНУ	178.7	6.2	118.6	4.8	103.7	3.2
Бусад	483.8	16.7	416.1	16.9	536.9	16.5

Импортын дүнг авч үзвэл, 2021 оны эхний хагас жилд, БНХАУ 40.2, ОХУ 26.0, Япон Улс 6.3, БНСУ 4.3, ХБНГУ 3.6 хувийг тус тус эзэлж, нийт импортын 80.4 хувийг бүрдүүлж байна.


ОХУ-аас импортоор оруулсан барааны 49.5 хувийг нефтийн бүтээгдэхүүн, Япон Улсаас импортлосон барааны 67.7 хувийг суудлын автомашин, БНХАУ-аас импортлосон барааны 4.8 хувийг цахилгаан эрчим хүч, 16.1 хувийг ачааны тэрэг, 79.1 хувийг олон нэр төрлийн бага жинтэй, бараа бүтээгдэхүүн эзэлж байна.

Импорт өмнөх оны мөн үеэс 801.0 сая америк доллароор өсөхөд улаан буудайн импорт 41.5 сая америк доллар, ачааны автомашины импорт 163.0 сая америк доллар, дизелийн түлш 58.1 сая америк доллар, суудлын автомашины импорт 24.2 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 3. Импортын гол нэрийн нефтийн бүтээгдэхүүн, мянган тонноор, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Зураг 4. Тээврийн хэрэгслийн импортын хэмжээ, ширхгээр, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Эрдэс бүтээгдэхүүн, хүнсний бэлэн бүтээгдэхүүн, ургамлын гаралтай бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 85.6 хувийг эзэлж байгаа бол импортын 64.9 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг эд анги, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.

Хүснэгт 3. Экспорт, импорт, зарим барааны бүлгээр, сая америк доллар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	2019 I-VI	2020 I-VI	2021* I-VI	$\frac{2021^* \text{ I-VI}}{2020 \text{ I-VI}} \%$
Экспорт	3 939.0	2 828.2	4 111.3	145.4
Эрдэс бүтээгдэхүүн	3 307.5	2 020.6	3 389.4	167.7
Нүүрс	1 543.5	690.8	1 028.3	148.9
Зэсийн баяжмал	1 062.4	741.1	1 312.9	177.2
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	30.7	8.0	45.1	5.7 ¹
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	4.2	4.5	86.9	19.5 ¹
Нэхмэл бүтээгдэхүүн	271.6	118.4	248.0	2.1 ¹
Үнэт чулуу, металл, гоёлын зүйлс	196.3	607.1	221.3	36.5
Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	195.9	606.4	218.0	36.0
Импорт	2 893.8	2 460.1	3 261.1	132.6
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	202.1	197.7	278.9	141.0
Эрдэс бүтээгдэхүүн	621.9	485.4	551.9	113.7
Автобензин	148.9	116.0	118.6	102.3
Дизелийн түлш	315.4	205.1	263.1	128.3
Үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн зүйлс	267.1	235.6	247.1	104.9
Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги	587.3	374.1	708.7	189.4
Хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	165.4	173.0	270.5	156.3
Хуванцар, каучук, түүгээр хийсэн эдлэл	122.7	100.7	116.9	116.1
Машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл	583.4	526.4	576.6	109.5

¹ - Дахин их

Ойлголт, тодорхойлолт:

Гадаад худалдааны барааны нийт эргэлт: Экспорт, импортын нийлбэрээр тодорхойлно.

Гадаад худалдааны тэнцэл: Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

Импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн, хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.

Экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдийн засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.

Реимпорт: Өмнө нь экспортод бүртгэгдсэн дотоодын барааны импортыг ойлгоно.

Реэкспорт: Өмнө нь импортод бүртгэгдсэн гадаадын барааны экспортыг ойлгоно.

Эх орны үйлдвэрлэлийн бараа: Тухайн улс оронд импортоор оруулж, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.



Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын дарга

Э.Эрдэнэсан

Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын статистикч

Н.Адъяадорж

Утас : (976-51)-261563

